



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**БОГД ХААНЫ ОРДОН МУЗЕЙД
ИРГЭНИЙ ӨРГӨДЛИЙН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН
ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2026 он

ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Хяналт шалгалтын зорилго:

Монгол Улсын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвд иргэн О.Сайнжаргалын гаргасан гомдлын дагуу Богд хааны ордон музейтэй байгуулсан Занаду инженеринг групп ХХК-ны гэрээт ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн явцын талаар мэдээлэл цуглуулан, дүн шинжилгээ хийн дүгнэлт гаргах зорилгоор хяналт шалгалтыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт шалгалт хийсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хугацаа:

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгалан хянан удирдаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын бодлого төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч Ц.Алтанхуяг 2026 оны 05 дүгээр сарын 22-ны өдрөөс ажлын 5 өдрийн хугацаанд гүйцэтгэв.

Гурав. Хяналт шалгалтад хамрагдсан асуудал:

Иргэн О.Сайнжаргалын гаргасан *“Богд хааны ордон музей зураг төслийн ажил гүйцэтгэсэн мөнгөө олгохгүй байгаад гомдолтой байна. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж өгнө үү”* гэснийг санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагчийн албан тушаалтанд олгосон эрх, үүргийн хүрээнд хянаж шалгалаа.

Дөрөв. Шалгуулагч этгээд, хяналт шалгалтын объектын мэдээлэл:

Тус музей нь 1926-1940 онд Үндэсний музей, 1940-1941 онд Орон нутаг судлах музей, 1954 -1961 онд Улсын Төв музейн харьяа музей, 1961-1990 онд Богд хааны ордон музей, 1990-1991 онд Шашны түүхийн музей, 1991-1992 Шашны урлагийн музейн Богд хааны ордон музей, 1993-2000 онд Шашны түүхийн музейн Богд хааны ордон музей, 2000 оноос өнөөг хүртэл Богд Хааны ордон музей нэртэйгээр ажиллаж байна.

Богд Хааны Ордон музей нь 1926 оноос өнөөг хүртэл музейн үйл ажиллагаа явуулж байгаа Монголын ууган музей юм.

Тус музейд ХҮИ-ХХ зууны эхэн үеийн Монголын хаант төр, шашны түүх, урлаг, соёлын давтагдашгүй хосгүй үнэт дурсгалууд, тухайн үед амьдарч байсан нэрт урчууд, дархчуудын туурвисан уран зураг, зээгт наамал, модон сийлбэр, цаасан шумал, анхдугаар Богд Жавзандамба өндөр гэгээн Занабазар, түүний дэг сургуулиар урлаж бүтээсэн цутгамал бурхдыг үзэгч олонд дэлгэн үзүүлэхийн зэрэгцээ сан хөмрөгтөө хадгалж байна. Энд мөн Богд хаан болон түүний хатан Улсын Эх дагина Дондовдуламын өмсөж хэрэглэж байсан дээл хувцас, эдлэл, хэрэглэл, гадаад дотоодын зочид төлөөлөгчийн өргөсөн бэлэг дурсгал, худалдаж авсан эд зүйлс зэрэг багтдаг.

Тус музей 4214 дэсийн 8648 ш үзмэртэй ажиллаж иржээ.

Музей нийт 19 ажилтны орон тоотой соёлын үйлчилгээний төсвийн байгууллага бөгөөд захиргаа, аж ахуйн алба, сан хөмрөг, бүртгэл, судалгааны алба гэсэн хоёр албатайгаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Тав. Өмнөх хийсэн хяналт шалгалтын түүх:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 06 дугаар 23-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу тус байгууллагын 2025 оны эхний хагас жилийн байдлаарх Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудитыг гүйцэтгэсэн. Дотоод аудитаар шилэн дансны хөтлөлт 95.4 хувьтай хангалттай дүгнэгдсэн байна.

Зургаа. Хяналт шалгалтаар тогтоогдсон бодит нөхцөл байдал (илрүүлсэн зөрчил дутагдал, түүний шалтгаан нөхцөл, гарч болзошгүй буюу гарсан хохирол):

- 6.1 Богд хааны ордон музейн захирал Ц.Эрдэнэбаатар, Занаду инженеринг групп ХХК-ны захирал Б.Эрдэнэбат нарын хооронд 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр “Ажил гүйцэтгэх гэрээ” -г байгуулж, гэрээний хавсралтаар гүйцэтгэх ажлын даалгаврыг тохиролцсон байна. Музейн 5.1 га гадна талбайн тохижилтын зураг төсвийг 19,580.0 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээлсэн.
- 6.2 Гэрээний 2.2.1-д гэрээ хүчин төгөлдөр болсны дараа гэрээний төлбөрийн 70 хувь буюу 13,706.0 мянган төгрөгийн гүйцэтгэгчийн тоот дансанд нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ гэж заасан.
- 6.3 Гэрээний 3.1 ажил гүйцэтгэгч нь ажлын даалгаврыг хүлээн авснаас хойш 30 хоногийн хугацаанд гэрээт ажлыг хийж гүйцэтгэнэ гэжээ.
- 6.4 Гэрээний 6.1 хэрэв захиалагч хүндэтгэх шалтгаангүйгээр уг гэрээнд тогтоосон журмын дагуу төлбөрийг шилжүүлээгүй тохиолдолд ийнхүү хоцроосон хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.
- 6.5 Музейн Төрийн сан банк дахь 100 9000 34415 дугаар нэмэлт санхүүжилтийн дансанд 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар 442,784.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- 6.6 Сангийн яаманд холбогдох журмын хүрээнд санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг цахимаар 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр хүргүүлсэн байна. Үүнд:
 - Мэргэжлийн үйлчилгээний төлбөр зардлын эдийн засгийн ангилалд 19,580.0 мянган төгрөг;
 - Захирлын 2026 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн А/15 дугаар тушаал;
 - Занаду инженеринг групп ХХК-тай байгуулсан гэрээ;
 - Эх үүсвэрийг нотлох орлогын хуулга.
- 6.7 Богд хааны ордон музейн санхүүгийн ажилтнаас энэ асуудлыг тодруулахад “Санхүүжилтийн эрх нээлгэх талаар харьяалах яамны мэргэжилтэнтэй уулзаж санал хүсэлтээ баримт материалын хамт хүргүүлсэн, мөн Сангийн яамны эрх бүхий албан тушаалтанд хандахад харьяа яамаараа дамжуулан хүсэлтээ өгөх чиглэл өгсөн” тухай тайлбар мэдээлэл өгсөн.

- 6.8 Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 4.4 дэх заалтын дагуу Богд хааны ордон музейн жилийн төсвийн дундуур бий болсон нэмэлт орлогыг Сангийн яамны төсвийн санхүүжилтийн асуудад хариуцсан нэгж хүлээн авч хянасны үндсэн дээр **тухай бүр** нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээж санхүүжүүлнэ гэж заасан.
- 6.9 Энэ заалтын хүрээнд Сангийн яамны төсвийн санхүүжилтийн нэгж 2026 онд тус музейн санхүүжилтийн эрх нээлгэх 8 удаагийн хүсэлт гаргахад 4 удаа буюу 129,005.6 мянган төгрөгийн зарцуулалтын эрхийг 2026 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн байдлаар хянаж зөвшөөрсөн. Харин 04 дүгээр сарын 17-ноос хойш хүргүүлсэн 292.2 сая төгрөгийн 4 хүсэлтийг шийдвэрлэж өгөөгүй байна.
- 6.10 Сангийн яамны төсвийн санхүүжилтийн нэгжийн мэргэжилтэн А.Дэлгэрмаатай холбогдож энэ асуудлыг тодруулахад *“Ерөнхий сайдын 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын 5.7 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөөнөөс давсан орлогыг төрийн сангийн нээгдсэн дансанд татан төвлөрүүлэх, нэмэлт санхүүжилтийн дансаар хийгдэх гүйлгээнд хяналт, хязгаарлалт тогтоох арга хэмжээ авч ажиллах гэсэн заалтын хүрээнд санхүүжилтийн эрхийг олгоход хяналт тавьж ажиллаж байгаа, эрх нээхгүй гэсэн асуудал байхгүй”* гэж тайлбарласан.

7. Хяналт шалгалтын явцад авсан арга хэмжээ, өгсөн зөвлөгөө;

Хяналт шалгалтаар илэрсэн санхүүгийн эрсдэлийг арилгах, Занаду инженеринг групп ХХК-тай байгуулсан гэрээний дагуу санхүүжилтийг бүрэн олгож, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авах зөвлөмжийг хүргүүлж байна.

8. Шалгуулагч этгээдийн эрсдэлийн үнэлгээ, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал;

Богд хааны музейн 2025 оны үйл ажиллагааны орлогын зарцуулагдаагүй үлдэгдэл 386.2 сая төгрөгийг оны эцэст улсын төсөвт татан төвлөрүүлснийг Сангийн яамнаас байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр буцаасан ба энэ орлогоос зарцуулах эрхийн хүсэлтийг гаргахад Сангийн яам нь Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар албан даалгаврын 5.7 буюу *“... үндсэн үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөөнөөс давсан орлогыг ... хязгаарлалт тогтоох”* гэсэн заалтыг баримтлан санхүүжилтийг нээхгүй байгааг үндэслэлгүй гэж дүгнэв.

Мөн Богд хааны ордон музейн нэмэлт санхүүжилтийн дансанд 442.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй боловч Занаду инженеринг групп ХХК-тай байгуулсан гэрээний 2.2.1-д заасан төлбөрийн 70 хувь буюу 13,706.0 мянган төгрөгийн төлбөрийг Сангийн яамнаас нээж өгөөгүй тул гэрээний 6.1-д заасны дагуу өдөр тутам 0.3 хувийн алданги төлөх эрсдэл үүссэн гэж дүгнэв.

Хяналт шалгалтын дүнгээр илэрсэн байгууллагад үүсэх эрсдэлийг арилгуулах, дотоод хяналтыг сайжруулан ажиллахыг Богд хааны ордон музейн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаатарт даалгаж байна.

Зөвлөмж 1. Харилцагч байгууллагатай ажил гүйцэтгэх, бараа худалдан авах аливаа гэрээ хэлцэл байгуулахдаа төлбөрийн хуваарийг Сангийн яамнаас зарцуулалтын эрх нээснээс хойш ажлын 5 хоногийн дотор урьдчилгаа болон гүйцэтгэлийн санхүүжилтийг олгоно гэж гэрээний төлбөр төлөх хугацааны асуудлаас үүсэх санхүүгийн эрсдэлийг арилгах;

Зөвлөмж 2. Сангийн яамны төсвийн санхүүжилтийн нэгжид хяналт шалгалтын дүгнэлтийг хүргүүлэн, санхүүжилтийн эрхийг нээлгүүлж гэрээт ажлын төлбөрийг шуурхай барагдуулах арга хэмжээг зохион байгуулах;

Хяналт шалгалтын танилцуулгаар хүргүүлсэн дүгнэлтэд үндэслэн өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх.

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

---oOo---